

**ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

2023 оны 11 сарын 24

УБЕГазраас албан бичгээр ирүүлсэн 22 удаагийн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа.

1-рт. Иргэний бүртгэлийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газар, хэлтсийн даргаас өгсөн чиглэл, үүрэг даалгавар, зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Иргэний улсын бүртгэлтэй холбоотой нийт 14 үүрэг даалгавар, нөхөн сонгуультай холбоотой 8 үүрэг даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

- 2023 оны 01 сарын 25-ны өдрийн дотоод мэйлээр ирсэн 100 гаас дээш настай 5 иргэний бүртгэлийг тулгаж ирүүлнэ үү гэсний дагуу тус аймгийн харъяат 100 настай 2 иргэн, 99 настай 3 иргэний мэдээллийг статистикийн хэлтэс, улсын бүртгэгчидтэй тулган гаргаж хүргүүллээ.
- 2023 оны 01 сарын 11 -ний өдрийн 4/363 тоот албан бичгээр гадаад паспортын талаар авах арга хэмжээний тухай УБЕГазрын ИУБГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу гадаад паспортын бүртгэлийг тухай бүр баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд гадаад паспортын хэвлэгдэн ирж байгаа хугацаа богиносж түргэн шуурхай болсонд иргэд талархаж байгаа.
- УБЕГазрын ИУБГазраас тус аймгийн хэмжээнд нэг хаяган дээр 10-аас дээш иргэн бүртгэлтэй хаягийн жагсаалтыг ирүүллээ. Жагсаалтад 266 хаяган дээр нийт 3314 иргэн бүртгэлтэй байна. Дараах жагсаалтын дагуу мэдээллийн сангаас иргэдийн нэрсийг шалгаж тухайн хаяган дээрээ амьдардаг эсэх хаягийн зөрчилтэй байгаа тохиолдолд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийж зөрчил арилгах талаар сумдын бүртгэгчдэд хугацаатай үүрэг өгч ажиллалаа. Бүртгэлийн цахим системд хаяг зөрүүтэй гэж мэдээлэл өгсөн 7 иргэний бүртгэлийг шалган иргэдтэй холбоо барьж тус бүр мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.
- Аймгийн засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэст 3 удаа тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж тайлагнасан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээг улирал бүр Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна
- ГБХЗХГазарт үрчлэгдсэн хүүхдийн судалгааг 1 удаа гаргаж өгсөн.
- Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2023 оны 04 сарын 10-ны өдрийн шуурхай хурлаар тус аймгийн хэмжээнд нийт 1199 гадаад паспорт олгосон бөгөөд хурууны хээгээр бүртгэл хийсэн 708, регистрийн дугаараар бүртгэл хийсэн 491 паспортын захиалгыг авсан. Регистрийн дугаараар гадаад паспортын бүртгэл хийсэн шалтгаан нөхцлийг олж илтгэх хуудсыг хүргүүлсэн.
- Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос **19042** иргэн буюу **59,4** хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 18 нэгжээр дамжуулан олгохоос гадна Аймгийн Засаг Даргын Тамгын газрын цахим үйлчилгээний хэсэгт байрлах бүртгэлийн үйлчилгээний Киоск машинаар дамжуулан олгож байна. 2023 онд 7041 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.
- УБЕГазрын 2023 оны 04 сарын 26 ны өдрийн 3/3791 тоот чиглэлийн дагуу
- улсын бүртгэгчид иргэний улсын бүртгэлийн зарим лавлагааг ИУБ хөтлөхдөө "албан хэрэгцээнд" зориулалтаар цаасаар хэвлэхгүй лавлагааг үүсгэсэн тухай түүхийг санд үүсгэн, журнал бүртгэлд тэмдэглэн бүртгэл хө Иргэний улсын бүртгэлийн газраас мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд 18 иргэний жагсаалт ирснийг санд шалган зөрчлийг арилгуулахаар хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар жагсаалтыг өглөө.
- Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх зорилгоор УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 11 сарын 9-ний өдөр ИУБГазраас 884 иргэний бүртгэлийн жагсаалт ирсэн. Уг жагсаалтын дагуу мэдээллийн санд цахимжаагүй иргэдийн хувийн хэргийг цахимжуулах хугацаатай үүрэг даалгаврыг хүлээн авч иргэний улсын бүртгэгч, архивчид 5 хоног ажиллаж хувийн хэрэг цахимжаагүй,

дутуу цахимжсан 480 хувийн хэргийн 1440 маягтыг архивын санд цахимжууллаа. Архивт хувийн хэрэг байхгүй шилжин явсны бүртгэлд бүртгэгдсэн 370 иргэн байсан. Регистрийн дугаар нь давхар бүртгэгдсэн 10 бүртгэл, бүртгэл тодорхойгүй 24 бүртгэл гарсан. Мэдээллийг хугацаанд нь шалган цахимжуулж тайланг илтгэх хуудсаар хүргүүлсэн.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын Т.Гантөмөр даргаар ахлуулсан ажлын хэсэг 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж ажиллалаа. Улсын бүртгэлийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал"-ын хүрээнд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаа холбогдох хууль, дүрэм, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд дотоод аудит хийж, зөвлөмж өгөх, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөн тусалж ажиллалаа.

Нөхөн сонгуулийн ажлын хүрээнд хийгдсэн ажлууд

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, "Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам", Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд УБЕГ-аас өгсөн заавар, цахим чиглэлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Тус аймгийн Баянжаргалан сумын ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01 тоот тогтоол "Орон нутгийн Хурлын нөхөн сонгуулийн тов зарлах тухай", Адаацаг сумын ИТХ-ын 2023 оны 02 сарын 9-ний өдрийн 01 тоот тогтоол " Нөхөн сонгуулийг товлон зарлах тухай", Хулд сумын ИТХ-ын 2023 оны 01 сарын 30-ны өдрийн 14/01 тоот тогтоол " Нөхөн сонгуулийг товлон зарлаж, хэсгийн тоо, нутаг дэвсгэрийн төвийн байршил тогтоох тухай, Өлзийт сумын ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 65 дугаар тогтоол " Нөхөн сонгуулийн тов зарлах тухай " тогтоолуудыг хүлээн авч эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүллээ.
- Иргэний улсын ахлах бүртгэгч хэсэг байгуулсан тогтоолыг шивэх эрх авсан ба хэсгийн нутаг дэвсгэр, санал авах байрны мэдээллийг тогтоолуудтай тулган шалгаж, санал авах байр буюу хэсгийн төв түүнд хамаарах хаягийн мэдээллийг мэдээллийн санд шивж, баталгаажуулсан. Сонгуулийн эрх бүхий иргэний мэдээллийг давхардалгүй, үнэн зөв, бүрэн гүйцэд бүртгэсэн эсэхийг байнга нягтлан шалгаж ажилласан.
- Аймгийн хэмжээнд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зогсоож, энэ өдрөөс өмнө шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтөлж, баталгаажуулаагүй бүртгэл байхгүй буюу бүртгэсэн, алдаатай төлөвтэй бүртгэл байхгүй. 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хөтлөгдсөн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг баталгаажуулж дуусгасан. Шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан, дэвтэрт бүртгэсэн, иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулаагүй бүртгэл байгаагүй.
- Иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн чиглэлийн дагуу тус аймгийн Хулд сумын шувуутай багийн 5 иргэн нэрийн жагсаалтад бүртгэлгүй байна гэх мэдээллийг шалгаж үзэхэд иргэний бүртгэлийн мэдээллийн санд хаягтай боловч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлгүй байсан Election.gasr.mn программд хулд сумын 1-р баг шувуутай багт дээрх 5 иргэний хаяг нэмэгдэж ороогүйн улмаас сонгогчдын нэрийн жагсаалтад байхгүй байсан тул хаягийг нэмж оруулан шалгаж үзэхэд иргэдийн бүртгэл сонгогчдын нэрийн жагсаалтад орж ирж зөрчилгүй болсон.
- Сонгогчдын нэрийн жагсаалтыг election.gasr.mn хаягаар шалган ажилласан ба сонгогчийн нэрийн жагсаалттай холбоотой гомдол, санал ирээгүй. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл /гар хурууны хээ/-д шинээр, 25, 45 насанд сольж, хаяж, гээж, үрэгдүүлсэн шалтгаанаар дахин олгох бүртгэлд бүртгүүлж байгаа иргэдийн бүртгэлийг баталгаажуулахдаа иргэний байнга оршин суух хаягийн мэдээлэл, сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэрт бүртгэгдсэн эсэхийг тухай бүр нягтлан шалгасан.

- Иргэний улсын бүртгэлийн газраас сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах, хэрхэн яаж хэвлэх, хэдэн хувь хэвлэх, хэрхэн

ХЭВЛЭГДСЭН СОНГОГЧДЫН ТООН МЭДЭЭ

Тайлан 5

Д/д	Аймаг, нийслэлийн нэр	Сум дүүргийн нэр	Хэсгийн дугаар	Үндсэн				Түр хасав			Нийт
				Үндсэн	Цагдаагийн албан хаагч, Дотоодын цэргийн анги	Тусгай анги салбарын алба хаагч, ажилтан	Зэвсэгт хүчний цэргийн ангийн алба хаагч, ажилтан	Эрх зүйн чадамжгүй	Хорих анги, эрүүгийн хэрэг, албадан эмчлүүлсэн	Гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон	
1	Дундговь	Адаацаг	2-3	314	0	0	0	0	2	2	318
2	Дундговь	Баянжаргалан	3-1	185	0	0	0	0	1	2	188
3	Дундговь	Өлзийт	10-3	221	0	0	0	1	0	1	223
4	Дундговь	Хулд	13-1	311	0	0	0	1	0	2	314
				1,031.00	0.00	0.00	0.00	2.00	3.00	7.00	1,043.00

баталгаажуулах талаар өгсөн зөвлөмжийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх, хүргүүлэх ажлыг зохион байгууллаа. Тус аймгийн Сайнцагаан суман тогны хязгаарлалтыг 17.00 цаг хүртэл хязгаарлаж иргэний улсын бүртгэлийн газраас өгсөн заасан хугацаанд хэвлэж чадаагүй. Сонгогчдын нэрийн жагсаалтыг 17 цаг 30 минутад хэвлэж дууссан. Хэвлэхэд ямар нэг хүндрэл бэрхшээл учраагүй. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 4 хэсгийн 1043 иргэний жагсаалтыг улсын ахлах бүртгэгч тус бүр 2 хувь хэвлэн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч хяналт тавин хэлтсийн тамга, ахлах бүртгэгчийн тэмдгээр баталгаажуулан дугтуйлж хэсгийн хороодод хуулийн хугацаанд хүргүүлсэн.

- Итгэмжлэгдсэн ажилтны судалгааг 2023 оны 5 сарын 22-ны өдөр гаргаж ИУБГазрын ахлах бүртгэгч Б. Отгонд хүргүүлсэн.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн ажилтай холбоотой 7 ажлын хүрээнд хийгдсэн ажлуудыг тухай бүр илтгэх хуудсаар ch.battsetseg@burtgel.gov.mn хаягаар хүргүүлэн ажилласан.
- Нөхөн сонгууль тус аймгийн Адаацаг 3- баг, Баянжаргалан 1-р баг, Хулд 1-р баг, Өлзийт 3- р багуудад явагдсан бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй 1031 сонгогчоос 398 сонгогч санал өгч 38,6 хувьтай явагдлаа.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

2023 оны 11 сарын байдлаар ИГББүртгэлийн **1219** бүртгэл, шилжилт хөдөлгөөний **1694** бүртгэл, гадаад паспортын **2443** бүртгэл, иргэний үнэмлэхийн **1799** бүртгэл, лавлагааны **3722** нийт **10877** иргэнд бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ.

E-Mongolia цахим системээс иргэний улсын бүртгэлийн **16** төрлийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний **9**, улсын бүртгэлийн **13** төрлийн лавлагаа нийт улсын бүртгэлийн **13** төрлийн лавлагаа нийт **38** төрлийн үйлчилгээг авах боломжтой.

2023 онд E-Mongolia цахим системээс гэрлэсний бүртгэлгүй **84** лавлагаа, гэрлэлтийн бүртгэлийн **115**, иргэний үнэмлэх дахин захиалсан **61**, иргэний үнэмлэхийн лавлагаа **930**, төрсний гэрчилгээний лавлагаа **300**, оршин суугаа хаягийн лавлагаа **750** нийт **2240** иргэн бүртгэлийн лавлагаа мэдээлэл авч үйлчлүүлсэн байна. Нийт лавлагааны **88,3** хувийг иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хаягийн лавлагаа эзэлж байна.

Тайлант хугацаанд нийт **2443** иргэнд гадаад паспортын үйлчилгээг үзүүлсэн бөгөөд шинээр гадаад паспорт захиалсан **1085**, дахин захиалсан **1358** иргэн байна. Үүнээс **1487** иргэнд цахим гадаад паспорт, **956** энгийн паспорт олголоо. Дахин гадаад паспорт захиалж байгаа иргэдийн өмнөх паспортыг мэдээллийн санд тухай бүр хүчингүй болгож байгаа ба **1586** иргэний хуучин паспортыг хүчингүй болгосон байна.

2023 оны 01 дүгээр сараас эхлэн ИУБГ, МТГ-аас хийсэн 3 удаагийн гадаад паспортын программын болон эрх зүйн цахим сургалтад гадаад паспортын бүртгэл хариуцсан бүртгэгч, иргэний улсын ахлах бүртгэгч нар оролцож цахим гадаад паспортын зураг авах, цахим гадаад паспортын захиалга авахад программын сургалтад хамрагдсан. 2023 оны 03 сарын 1-ний өдрөөс олгож эхэлсэн цахим гадаад паспортын эрхийг нэг цэгийн

үйлчилгээний 2 иргэний улсын бүртгэгчид нээлгэж **1487** иргэнд цахим гадаад паспорт олгосон бөгөөд бэлтгэл ажлыг бүрэн ханган ажилласнаар цахим гадаад паспорттай холбоотой гомдол санал ирээгүй захиалга хэвийн явагдаж байна. ИУБГазраас өгсөн чиглэлийн дагуу гадаад паспортын бүртгэлийг тухай бүр баталгаажуулан ажилласан. Гадаад паспортын бүртгэлийг 2 улсын бүртгэгч хийж байгаа ба анхан шатны нэгжид үзүүлж байгаа бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх зорилгоор гадаад паспортын бүртгэл хөтлөх эрхийг 4 нэгжид авах хүсэлтийг УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн боловч одоогоор нэгжид гадаад паспортын эрх олгох асуудлыг орон нутагт шийдвэрлэх болоогүй гэсэн хариу өгсөн. Зөврийн 4 жи тоног төхөөрөмжийг ашиглан аймгийн 14 суманд бүртгэлийн өдөрлөгөөр 203 иргэнд гадаад паспортыг газар дээрээс нь захиалах боломжийг олгож ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн “Иргэний үнэмлэхийн зураг засварын программ ашиглах заавар, анхаарах асуудал” сэдэвт цахим сургалтын дагуу Мэдээлэл технологийн газраас **470** иргэний зургыг хүлээн авч, мэдээллийн санд нэг бүрчлэн нягтлан шалгаж, зөрчилгүй тухай илтгэх хуудсыг иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн. Иргэний үнэмлэх шинээр **550**, хаяж үрэгдүүлэн дахин авсан **350**, хугацааны сунгалтаар **899** иргэнд иргэний үнэмлэх олгосон байна. Төрөлтийн бүртгэл **741**, гэрлэлтийн бүртгэл **147**, үрчлэлт **12**, гэрлэлт цуцлалтын бүртгэл **26**, эцэг тогтоолтын бүртгэл **21**, ОНӨ бүртгэл **38**, нас барсны бүртгэлд **240** шилжилт хөдөлгөөний бүртгэл **1694**, гадаад паспортын бүртгэл **2443** нийт **5362** бүртгэлийг мэдээллийн санд баталгаажууллаа. Эрүүл



мэндийн яамны мэдээллийн сангаас 741 хүүхдийн регистрийн дугаарыг унагаж төрсний бүртгэлд бүртгэсэн бөгөөд 167 эрэгтэй, 174 эмэгтэй хүүхэд төрсөн байна.

Төрсөн эхчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-19 насны 39, 20-24 насны 179, 25-29 насны 184, 30-34 насны 118 эмэгтэй төрсөн нь нийт төрсөн эхчүүдийн 70,1 хувийг эзэлж байна. Батлуулсан гэр бүлтэй 323 эмэгтэй, батлуулаагүй гэр бүлтэй 309 эмэгтэй төрж бүртгэгдсэн байна. Бүрэн дунд боловсролтой 284, дээд боловсролтой 269 эх төрсөн байна. Нийт төрсөн хүүхдийн 59,9 хувь буюу 444 хүүхэд Сайнцагаан суманд төрсний



бүртгэлд хамрагдсан байна.

Нийт **3742** лавлагаа хэвлэсэн бөгөөд хууль тогтоомжийн дагуу хууль хяналтын байгууллагын хүсэлтээр **342** лавлагаа, шүүхийн байгууллагын хүсэлтээр нотлох баримтын түвшинд **170** маягтын хуулбар нийт **512** лавлагаа мэдээллийг албан тоотын дагуу гаргаж хүргүүлсэн. Үүнд цагдаагийн байгууллагын хүсэлтээр албан тоотын дагуу **144**, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн

хүсэлтээр **160**, Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн хүсэлтээр **37**, лавлагааг тус тус олгосон. Нийт **3722** лавлагаа хэвлэсэн бөгөөд хууль хяналтын байгууллагын хүсэлт, албан тоотор **390**, албан хэрэгцээнд **827**, иргэнд **2487** лавлагааг иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас олголоо. 2023 онд E-Mongolia цахим системээс **2240** иргэн бүртгэлийн лавлагаа мэдээлэл авч үйлчлүүлсэн байна. Нийт лавлагааны **88,3** хувийг иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хаягийн лавлагаа эзэлж байна.

Тайлант хугацаанд **1694** иргэн шилжин ирсний бүртгэлд хамрагдсанаас гадны аймаг хотоос **426** иргэн бүртгэгдсэн. Үүнээс 16-аас дээш насны **237** иргэн, 16-аас доош насны **189** иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдаж, **1268** иргэн аймаг дотор буюу сумаас суманд, багаас багт шилжин ирсэн бүртгэл хийлгэсэн байна. Улаанбаатар хотоос 216 иргэн, Төв аймгаас 25, Өмнөговь 47 Говьсүмбэр аймгаас 21 иргэн шилжин ирсэн нь нийт шилжин ирсэн бүртгэлийн 72,5 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд **1324** иргэн өөр аймаг хотод шилжин явснаас 16- аас доош насны **550**, 16-аас дээш насны **777** иргэн өөр аймаг хотод шилжин явсан хөдөлгөөний бүртгэлд хамрагдсан байна .

Тоон гарын үсгийг **16174** иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, **2869** иргэнд гар утасны gsign апплейшнаар дамжуулан олголоо. Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 4 жи төхөөрөмжөөр аймгийн төвийн ерөнхий боловсролын 4 сургууль, Сайхановоо , Сайнцагаан, Дэлгэрхангай, сумдад зохион байгуулагдсан багийн иргэдийн өдөрлөгт 3 удаа тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан. Номин супер маркетэд ажиллаж 56 иргэнд зөөврийн 4 жи төхөөрөмжийг ашиглан тоон гарын үсэг олгосон. Мөн Хаан банк, Улсын бүртгэлийн ерөнхий газраас хамтран зохион байгуулсан тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аяны хүрээнд 6 дугаар сард олгосон тоон гарын үсэг олголтоор тус аймаг 3-р байр эзлэн мөнгөн шагналаар шагнуулсан.

Бүртгэлийн үйлчилгээний киоск машинаар дамжуулан иргэний бүртгэлийн 12 төрлийн лавлагаа, иргэний үнэмлэх дахин авах, гадаад паспортын зураг илгээх, оршин суугаа хаягийн шилжилт хөдөлгөөн , цахим иргэний үнэмлэхийн мэдээлэл, тоон гарын үсэг авах зэрэг 5 төрлийн үйлчилгээг иргэд авч байна.

Бүртгэлийн төлбөр тооцооны “Гэрэгэ системийг Сайнцагаан, Дэрэн, Эрдэнэдалай сумдад ашиглаж байгаа бөгөөд 2023 онд бүртгэлийн үйлчилгээний нэг цэгийн танхимд байрлах D83 төхөөрөмжөөр **5735**, Дэрэн сумын D152 төхөөрөмжөөр **376**, Эрдэнэдалай сумын D179 төхөөрөмжөөр **258** нийт **6368** бүртгэлийн үйлчилгээний төлбөрийг Гэрэгэ системээр тушаасан байна.

Сайнцагаан сумын бүртгэгчийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа төлбөрийн пос машинаар **1300** иргэн бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог хийсэн байна. Төлбөр тооцооны системийг бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлсэн нь үйлчилгээний шат дамжлага буурсан, цаг хугацаа зардал хэмнэсэн үйлчилгээ болж чадлаа.

Иргэний улсын бүртгэлийн газраас улсын ахлах бүртгэгчдэд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн эрхийг 2022 оны 11 сард олгож мэдээллийн санд зөрүүтэй алдаатай бүртгэлийг нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр засварлах боломжийг өгсөн нь цаг хугацаа, шат дамжлагыг бууруулсан шийдвэр байлаа. Иргэний бүртгэлийн

мэдээллийн сангийн үнэн зөв байлгах иргэдийг цахим орчноос бүртгэлийн үйлчилгээ болон лавлагаа мэдээллийг авахад түргэн шуурхай чирэгдэлгүй авах боломжийг хангах зорилгоор иргэний бүртгэлийн санд зөрүүтэй 140 бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулж мэдээллийн санд алдаагүй болгож ажилласан. Нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг 0-16 насны хүүхдийн төрөлтийн бүртгэлд УБЕГазрын Хяналт шалгалтын газрын улсын ахлах байцаагч Ч. Эрдэнэчимэгийн 2022 оны 03 сарын 03-ны өдрийн 1543 тоот дүгнэлт, 16-аас дээш насны иргэний нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны 02- сарын 03-ны өдрийн 871 тоот дүгнэлтүүдийг тус тус үндэслэн оруулсан.

2023 оны 11 сараас эхлэн нэмэлт өөрчлөлтийн бүртгэл болон нөхөн бүртгэлийн эрхийг улсын ахлах бүртгэгчдэд шат дараатай нээж өгснөөр анхан шатанд иргэний улсын



бүртгэлийн мэдээллийн санд зөрчлийг арилгах боломжтой боллоо.

УБЕГазрын хяналт шалгалтын газраас нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд хяналт орж 18 бүртгэлийн дүгнэлтийн дугаарыг оруулаагүй зөрчлийг арилгуулах тухай улсын байцаагчийн албан шаардлагын дагуу УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Б. Отгоноос зөвлөмж авч 13 бүртгэлийн дүгнэлтийн дугаарыг цахимжуулж, 2 иргэний гэрлэлтийг нөхөн бүртгэлээр мэдээллийн санд оруулж овог нэр, эцэг тогтоолтын 2 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн 2788 тоот дүгнэлтийг гаргуулан хувийн хэрэгт цахимжуулан гарсан зөрчлийг бүрэн арилгаж ажиллалаа.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас мэдээллийн сан цэгцлэх ажлын зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 9 сарын 23-нд тус аймгийн 16 иргэний регистрийн дугаар бүхий жагсаалтыг ирүүлж мэдээллийн санд зөрчлийг арилган ажиллаж илтгэх хуудсыг ирүүлэх тухай үүрэг өгсөн. Тус иргэдийн жагсаалтыг мэдээллийн сан, архивын нотлох баримттай тулган шалгахад нөхөн бүртгэсэн, баталгаажсан төлөвтэй ямар нэг алдаагүй 13 бүртгэл, төрөлтийн бүртгэлд давхардан орсон 1, эцэг тогтоолтын бүртгэл мэдээллийн санд 2 удаа орж баталгаажсан 1 бүртгэл, төрөлтийн бүртгэлд эцэг эхийн мэдээлэл тусгагдаагүй 1 бүртгэл байсан. Төрөлтийн бүртгэлд эцэг эхийн мэдээлэл ороогүй байсан бүртгэлийн архивын нотлох баримтад үндэслэн мэдээллийг нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр зөрчилгүй болгож, эцэг тогтоолтын бүртгэл, төрөлтийн бүртгэл 2 удаа орсон байсан бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн 6225, 6226 тоот дүгнэлтээр мэдээллийн сангийн зөрчлийг ИУБГазарт хүргүүлэн холбогдох өөрчлөлтийг орууллаа.

Үнэт цаасны тайланг 11 удаа гаргаж өгсөн. Улсын бүртгэгчид үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон санхүүд гаргаж өгдөг. 2023 онд иргэний улсын бүртгэлийн 77 үнэт цаасыг бүртгэгчид хүчингүй болгосон байна. Үүнд: Адаацаг-3, Баянжаргалан-16, Говьугтаал-3, Гурвансайхан-1, Дэлгэрцогт-1, Дэлгэрхангай-8, Луус-2, Өлзийт-5, Өндөршил-5, Сайнцагаан -23, Хулд-2, Цагаандэлгэр 7, Эрдэнэдалай-1. Хүчингүй болгосон үнэт цаасыг хяналтын улсын байцаагч, байгууллагын өмч хамгаалах комиссоор оруулан бүртгэгчдийн алдаатай үйл ажиллагаанаас хүчингүй болсон үнэт цаасны төлбөрийг тухай бүр төлүүлэн хяналт тавин ажиллаж байна. Хүчингүй болгосон үнэт цаас өнгөрсөн онтой харьцуулахад 30,8 хувиар буурсан байна.

Иргэний бүртгэлийн архивын талаар

Тайлант хугацаанд төрөлтийн бүртгэлд **741**, гэрлэлтийн бүртгэл **147**, үрчлэлт **12**, гэрлэлт цуцлалтын бүртгэл **26**, эцэг тогтоолтын бүртгэл **21**, ОНӨ бүртгэл **38**, нас барсны бүртгэлд **240** шилжилт хөдөлгөөний бүртгэл **1694**, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн **1580** маягт нийт **4499** бүртгэлийн маягтыг архивт хүлээлгэн өглөө.


Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах ажлын хүрээнд иргэний гэр бүлийн **1219** бүртгэлийн **3657** хуудас, иргэний үнэмлэхийн **1200** бүртгэлийн **2400** хуудас, шилжилт хөдөлгөөний **797** бүртгэлийн **3188** хуудас, гадаад паспортын **2443** бүртгэлийн **1800** хуудас нийт **5659** бүртгэлийн **11045** хуудас баримтыг цахимжуулсан байна. Иргэний улсын бүртгэлийн ахлах бүртгэгчийн зүгээс 2023 оны цахимжуулалтын бүртгэлд хяналт хийж дутуу цахимжуулсан 6 бүртгэл, бүртгэгчийн гарын үсэггүй 4 бүртгэл, нотлох баримт дутуу цахимжуулсан 18 бүртгэл хийт 28 бүртгэлийн цахимжуулалтын зөрчлийг арилгаж ажилласан. Мөн Цагаандэлгэр, Говьугтаал сумдын улсын бүртгэгчид өөр ажилд шилжин ажилласантай холбогдон ажил хүлээн авах явцад бүртгэлийн анхан шатны нотлох баримт, журнал бүртгэл болон бүртгэлийн цахимжуулалтад хяналтыг хийж цахимжуулалт дутуу хийгдсэн 6 бүртгэлийг газар дээр нь цахимжуулж зөрчлийг арилган ажилласан. Хяналтын улсын байцаагчаас 2022 оны 10 сарын 1-ний өдрөөс 2022 оны 11 сарын 1-ний өдөр хүртэлх 400 бүртгэлийн анхан шатны нотлох баримтын цахимжуулалтад хяналт орж улсын бүртгэгчдэд цахимжуулалтын явцад шаардлага хангахгүй цахимжуулсан бүртгэлийг дахин цахимжуулах, эх нотлох баримтыг цахимжуулахад анхаарах асуудлаар заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Биеийн давхцахгүй өгөгдлийн ИУБ- 31 маягт 1212, ИГББүртгэлийн ИУБ-11-18 маягт 932 нийт 2144 маягтыг Иргэний баримтын төв архивт хүргүүлээ. Өөр аймаг хот, нийслэлд шилжин явсан 727 иргэний хувийн хэргийг тухайн шилжин суурьшсан аймаг

нийслэл рүү хүргүүлсэн бөгөөд шилжин ирсэн 211 иргэний хувийн хэргийг хүлээн авч архивын санд байршууллаа.

Сургалт, сурталчилгаа:

- УБЕГазрын Иргэний улсын бүртгэлийн газраас “Иргэний үнэмлэхийн зураг засварын программ ашиглах заавар, анхаарах асуудал”, “Цахим гадаад паспортын программын танилцуулга”, ны “Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх”, “Цахим гадаад паспортын талаар чиглэл өгөх”, “Засвар өөрчлөлтийн бүртгэлийн талаар чиглэл өгөх”, “ НАГ-аас болон тамгын газрын хамтарсан чиглэл өгөх”, “ХШГ болон ИУБГ-ын хамтарсан албан шаардлагын талаар чиглэл хүргүүлэх”, “Д.Дэлгэрсайхан-Аймаг, дүүргийн УБХ-ийн дарга, иргэний ахлах, Нэгдсэн төвүүдийн ахлахуудад чиглэл хүргүүлэх” талаар ахлах бүртгэгч нарт чиглэл өгөх тухай, сумдын улсын бүртгэгч нарт “Иргэний улсын бүртгэлтэй холбоотой асуудал” сэдвээр арга зүйн 11 удаагийн онлайн сургалт, ахлах бүртгэгч нарт зориулсан



1 удаагийн танхимын сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан.

- Шинэ загварын иргэний үнэмлэх хэвлэгдэн ирж байгаатай холбогдон улсын бүртгэгчдэд мэдээлэл хийж иргэдэд иргэний үнэмлэхийн талаарх мэдээллийг хүргэж ажиллахыг зөвлөлөө.
- Цахим гадаад паспорт хэвлэгдэж эхлэхтэй холбоотой УБЕГазрын ИУБГазраас явуулсан онлайн сургалтад тус тасгийн 3 бүртгэгч хамрагдсан. Мөн сургалтын системд тавигдсан онлайн хичээлийг судалж байна.
- Тоон гарын үсгийг эрчимжүүлэх талаар бүртгэгчдэд онлайн сургалт 2 удаа зохион байгуулсан.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн бөгөөд хэлтсийн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохионбайгуулсан. Тус сургалт дээр Байгууллагын үйлчилгээний стандарт сэдвээр албан хаагчдад мэдээлэл хүргэсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар бэлтгэсэн 20 асуулт бүхий шалгалтыг улсын бүртгэгчид өгсөн
- Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдлийг бууруулах ажлын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэгч нарт бүртгэл хөтлөхөд гарч болзошгүй эрсдлийг бууруулах, мэргэжил арга зүйгээр хангах, тулгарч буй асуудлаар нэгдсэн ойлголт зөвлөмж чиглэл өгөх зорилгоор батлагдсан хөтөлбөрийн дагуу хэлтсийн албан хаагчид танхимаар, сумдын улсын бүртгэгчид цахимаар оролцлоо. Тус сургалтад “Эрсдэл гэж юу вэ, ” сэдвээр иргэний улсын бүртгэлд гарч болох эрсдэл, эрсдлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл бэлтгэж хүргэсэн.
- Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд Дундговь аймагт улсын бүртгэлийн үйлчилгээ, банк санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг шуурхай авах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн



хэлтэс, Нийгмийн даатгалтын хэлтэс, ХХҮГазар, банк санхүүгийн байгууллагууд чөлөөт уулзалтыг зохион байгууллаа. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, чирэгдэл үүсгэхгүй байх, иргэдийг цахим орчинд төрийн үйлчилгээ авах чадварыг нэмэгдүүлэх, байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулахад анхан шатанд шийдвэрлэж болох зарим асуудлыг хамтын ажиллагаан дээр шийдвэрлэх, холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах саналыг дээд шатны байгууллагууддаа хүргүүлэх саналуудыг нэгтгэн салбар бүрээр гаргалаа. Тус сургалтад оролцож мэдээлэл өглөө.

- ✚ 2023 оны 9 сарын 8-ний өдөр Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газраас зохион байгуулсан өгөгдлийн шинжилгээний программын сургалтад хамрагдлаа. Тус программаар аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээ, улсын бүртгэгчдийн бүртгэсэн бүртгэлд их өгөгдөл ашиглан дүн шинжилгээ хийж сурахад зориулсан олон төрлийн өгөгдлөөр шүүлт, хайлт анализ хийх боломжтой программ юм.
- ✚ 2023 оны 09 сарын 14-ний өдөр Иргэний улсын бүртгэлийн газраас нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэлийн эрхийг ахлах бүртгэгчдэд нээсэнтэй холбоотой чиглэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар хэрхэн яаж нэмэлт өөрчлөлтийн бүртгэл, нөхөн бүртгэлийг алдаагүй үнэн зөв мэдээллийн санд оруулахад анхаарах асуудал, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийг хийхэд хяналтын улсын байцаагчдын дүгнэлтийг ямар бүртгэл дээр үндэслэж оруулах зэрэг асуудлаар заавар зөвлөмж өглөө.
- ✚ УБЕГазрын Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газраас зохион байгуулсан гүйцэтгэлийн тайлан, үнэлгээний талаарх сургалтад хамрагдсан
- ✚ 2023 оны 09 сарын 30-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн газраас Сонгуулийн хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтад тус хэлтсийн ахлах бүртгэгч, иргэний улсын бүртгэлийн 2 бүртгэгч нийт 3 албан хаагч хамрагдсан.
- ✚ Шинээр томилогдсон Говьугтаал, Цагаандэлгэр сумдын улсын бүртгэгчдийг Сайнцагаан сумын ажлын байранд тонгог төхөөрөмж, бүртгэлийн программ дээр дадлага хийлгэхээс гадна, иргэний улсын бүртгэлийн талаарх хууль, дүрэм журмыг танилцуулан заавар зөвлөмжөөр 3 удаа хангаж ажиллаж байна.
- ✚ 2023 оны 01 дүгээр сарын 09-нд Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас “Шинэ хуулийн төсөл”, 2023 оны 03 дугаар сарын 03-нд Монгол банкнаас “Цахим залилан”, 2023 оны 04 дүгээр сарын 12-нд ХААН банкнаас “Аяны хүрээнд хамтран ажиллах” сэдэвт сургалтуудад бүх албан хаагчид оролцсон.

- Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн тасгаас 21 удаагийн сургалт мэдээллээр 7800 иргэнд бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилж ажилласан байна. УБЕГазар, Иргэний бүртгэлийн хууль тогтоомж, үйл ажиллагаатай холбоотой 16 мэдээ мэдээллийг УБЕГазрын вэйб хуудас, Улсын бүртгэлийн ерөнхий газрын фэйж хуудаснаас Дундговь улсын бүртгэлийн хэлтэс нээлттэй групп, Бүртгэлийн хэлтсийн фэйж хуудсанд шэйр хийж түгээсэн. Дундговь аймгийн засаг дарга Ж. Мөнхбат түүний тамгын газраас “Иргэдээ сонсьё” өдөрлөгийг 2023 оны 02 сарын 06-12 ны өдрүүдэд Дэрэн, Цагаандалгар, Говьугтаал, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт сумд мөн 2023 оны 5 сарын 15-23 ны өдрүүдэд аймгийн баруун сумд болох Луус, Хулд, Дэлгэрхангай, Сайхановоо, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрцогт сумдад зохион байгуулсан. Тус өдөрлөгт улсын бүртгэлийн хэлтсээс иргэн, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр иргэдэд бүртгэлийн үйлчилгээг хүргэж ажилласан. Нийт 203 иргэн гадаад паспорт захиалж, 188 иргэн тоон гарын үсэг авч, 58 иргэнд бүртгэлийн чиглэлээр мэдээлэл зөвлөгөөг хүргэж нийт 449 иргэнд бүртгэлийн үйлчилгээг хүргэж ажилласан.



- 2023 оны 5 сарын 10-ны өдөр Дэлгэрхангай суманд зохион байгуулагдсан “ Малчны өдөрлөгт” оролцон 250 иргэнд мэдээлэл хүргэж 48 иргэнд тоон гарын үсэг олголоо - Аймгийн засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн №1 захирамжаар “Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил ”болгон зарласан бөгөөд Улсын бүртгэлийн хэлтсээс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг энгийн ойлгомжтой хэлбэрээр сурталчлах зорилгоор “Бүртгэгч багш ” мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж ирсэн. Энэ удаа Сайнцагаан сумын “Мандал” сургуулийн 10,11 дүгээр ангийн 45 сурагч, Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн 40 сурагчийг хамруулан зохион байгууллаа. Говьугтаал, Дэрэн сумдын улсын бүртгэгчид сумынхаа ерөнхий боловсролын сургуулийн 65 сурагчдын дунд “Бүртгэгч багш” өдөрлөгийг зохион байгуулсан байна. Мөн өдөрлөгийн үеэр “Алтан хонх” танин мэдэхүйн тэмцээнийг явуулж түрүүлсэн сурагчдыг урамшуулсан байна.



Улсын бүртгэлийн ерөнхий газар, ХААН банкны хамтын ажиллагааны хүрээнд “Тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх аян” –г 2023 оны 04 сарын 3-ны өдрөөс 2023 оны 06 сарын 30 хүртэл зарлан тоон гарын үсэг олголтыг идэвхжүүлэх, иргэдийн тоон гарын үсгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд ХААН банкин дээр үйлчлүүлж байгаа иргэдэд 4 жи төхөөрөмжийг ашиглан тоон гарын үсэг олгож ажлыг зохион байгуулсан.



статистик тоон мэдээгээр инфографик мэдээллийг 11 удаа бэлтгэн мэдээлэл технологийн ажилтанд гаргаж өглөө.

-2023 оны 6-ны өдөр Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “Малчдын сургалт, зөвлөгөөн -2023” өдөрлөгт оролцож 54 иргэнд тоон гарын үсэг олголоо. -2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Өлзийт Өлзийт сумын Засаг даргын тамгын газартай хамтран улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэх зорилгаар тус сумын Буянт багт “Нээлттэй хаалганы өдөрлөг ” зохион байгууллаа.Тус өдөрлөгөөр иргэний бүртгэлийн талаарх мэдээ мэдээллийг 18 иргэн, тоон гарын үсэг олголт 21,

гэрлэлтийн бүртгэл 2 нийт 41 иргэнд үйлчилгээг хүргэлээ. Мөн энэ өдөр гэрлэлтээ батлуулсан 2 хосын гэрлэлтийг ёс төртэй баталж гэрлэлтийн гэрчилгээ, дурсгалын зүйлийг гардууллаа.

Тус хэлтэс нь “Гэрлэх ёслол”-ын ажиллагааг 2013 оноос эхлэн зохион байгуулсан бөгөөд энэ жил Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран Сайнцагаан суманд 5, Өлзийт суманд 2, Хулд суманд 2, Дэлгэрхангай суманд 1 гэрлэлт нийт 10 хосын гэрлэлтийг ёслол хүндэтгэлтэй баталлаа. Шүүхийн шийдвэр



гүйцэтгэх газарт хоригдож байгаа 2 иргэний гэр бүлийн хүсэлтээр зөөврийн төхөөрөмжийг ашиглан гэрлэлт бүртгэх ажлыг зохион байгуулсан.

-Сайнцагаан сумын ахмадуудад иргэний үнэмлэх дахин захиалах, тоон гарын үсэг хэрхэн авах түүний хэрэглээ сэвдээр мэдээлэл хүргэж зөөврийн төхөөрөмжөөр 12 ахмадад тоон гарын үсэг олголоо. Нийт 52 ахмад хамрагдсан. - Сайхановоо суманд 11 сарын 3,4-ний өдрүүдэд зохион байгуулагдсан 4 багийн малчдын өдөрлөгт оролцон 4 жи төхөөрөмжөөр бүртгэлийн үйлчилгээг хүргэж ажиллалаа. Тус өдөрлөгөөр тоон гарын үсэг олголт 85, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 5, эцэг тогтоолтын бүртгэл 2, гэрлэлтийн бүртгэл 1,иргэний үнэмлэх хаяж үрэгдүүлсэн 3, мэдээлэл зөвлөгөөг 26 иргэн нийт 122 иргэнд бүртгэлийн үйлчилгээг хүргэж ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

- 2023 оны 3 сарын 1-ны өдрөөс цахим гадаад паспорт хэрэглээнд нэвтэрч цахим гадаад паспортын ач холбогдлыг иргэд цахим орчин, сурталчилгаа мэдээллээс мэдсэнээр цахим гадаад паспорт захиалж авах хүсэлтэй иргэд нэмэгдсэн. Нийт 2443 гадаад паспорт олгосноос 1487 буюу 60,9 хувь нь цахим гадаад паспорт захиалсан байна. Гадаад паспортын хэвлэлтийн хурд сайжирснаар орон нутагт захиалсан гадаад паспортын хэвлэгдэн ирж байгаа хугацаа 2 дахин буурсан.
- Хууль хяналтын байгууллагаас авч байгаа лавлагаа мэдээллийн тоо ялангуяа сүүлийн 2 сард цагдаагийн байгууллагаас цаасаар авч байгаа лавлагаа мэдээллийн тоо буурсан үзүүлэлттэй байна.
- Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэхтэй холбоотой тайлант онд 884 иргэний жагсаалт ирснээс дутуу цахимжуулсан, цахимжилт хийгдээгүй байсан 480 хувийн хэргийн 1440 маягтыг архивын санд цахимжуулсан нь иргэний бүртгэлийн сан болон цахим сан, E-Mongolia цахим системээс лавлагаа авахад иргэдийг чирэгдүүлэхгүй үнэн зөв мэдээ мэдээллээр хангах боломж бүрдсэн.
- Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн зөрчлийг арилгах нэмэлт өөрчлөлтийн бүртгэл, нөхөн бүртгэлийн эрхийг ахлах бүртгэгч нарт өгсөн нь анхан шатанд бүртгэлийн зөрчлийг түргэн шуурхай шийдвэрлэх боломж олгож цаг хугацаа, шат дамжлагыг бууруулсан шийдвэр болж чадсан.
- Бүртгэлийн үйлчилгээний төлбөр хураамжийг Гэрэгэ, пос машинаар тушаалгаж байгаа нь үйлчилгээний шат дамжлага, цаг хугацааг хэмнэсэн иргэдийн талархалыг хүлээсэн үйлчилгээ болж чадсан. Энэ онд Гэрэгэ системээр 5735, пос машинаар 1300 нийт 6368 иргэн үйлчлүүлсэн байна.

2-рт ЭХЭУБүртгэлийн чиглэлээрхэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд

4-рт Мэдээлэл Технологи, ил тод байдлын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд

Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмж, сүлжээний эвдрэл гэмтлийн засвар үйлчилгээ, программын шинэчлэлт хийх зэрэг ажлуудыг тухай бүрт нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа. Үүнд:

Иргэний бүртгэгчийн 2, Иргэний тасгийн дарга 1 компьютерт цахим гадаад паспортын программ суулгасан. Дэлгэрхангай, Дэрэн, Хулд, Луус, Говь-Угтаал, Өлзийт сумдын бүртгэгчийн нөүтбүүк тоон гарын үсэг программ суулган 4g төхөөрөмж таниулсан. Эд хөрөнгийн тасгийн дарга Л.Мөнхсарнай scanner алдаа зассан ба нөүтбүүк windows 10 үйлдлийн систем болон шаардлагатай программуудыг суулгасан. Хяналтын улсын байцаагч Д.Нямсүрэн нөүтбүүк boot 2 удаа зассан. МТА принтер paper jam алдаа, Нягтлан принтер хэвлэхгүй алдаа, Иргэний бүртгэгч принтер хэвлэхгүй зэрэг нийт 5 алдаа зассан байна. Дотоод сүлжээ тасалдсан тул унтрааж асаан УБЕГ-ээр хянуулсан. Киоск машин цаас дуусах, хэвлэхгүй байх, сүлжээгүй болох, нууц үг нэхэх зэрэг алдааг тухай бүр нь засварлаж ажилласан ба киоск орчны тохижилт, харагдахгүй тоо, логог шинэчилж пос машин холбосон. Зураг засвар программ иргэн 2 бүртгэгчид шинэчилж суулгасан. Даргын тоон гарын үсэг

зурагдахгүй алдааг зассан. Иргэний бүртгэгч компьютер асахгүй тэжээл шатсан тул Луус тоног төхөөрөмж угсарч хэвийн ажиллах орчин бүрдүүлсэн. Эд хөрөнгө Ганцэцэг шинээр сканнер таниулсан. Эд хөрөнгө Уугантуяа принтер хор цацаж хар хэвлэх алдаа зассан. Архив дотоод сүлжээ орохгүй алдаа зассан. Говь-Угтаал, Дэрэн, Сайнцагаан тоон гарын үсэг уншихгүй алдаа зассан. Эд хөрөнгийн бүртгэгч 2 компьютер windows 10 үйлдлийн систем суулгаж шаардлагатай программуудыг болон хурууны хээ уншигч таниулж суулгасан. Иргэний улсын бүртгэгч 2 компьютерт хурууны хээ уншигч суулгаад гацсан тул үйлдлийн системийг windows 7 болгож форматлав. Иргэний бүртгэгч Ш.Чулуунжаргалын, Гантөгс принтерийн хорны 2 чипийг сольсон. Говь-Угтаал, Өлзийт сумын сүлжээ тасалдсан тул суманд очиж сүлжээ зассан. Өлзийт сум суурин болон зөөврийн компьютер, Говь-Угтаал сум зөөврийн компьютерийг асахгүй, удаад уншаад нээгдэхгүй зэрэг гэмтлийг зассан.




Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдлыг ханган нууц үгийг улирал бүр буюу нийт 4 удаа, нэвтрэх нэр солих зэрэг ажлуудыг тухай бүрд нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа. Хэлтсийн албан хаагчдыг ERP цаг бүртгэлийн системд бүртгэж өглөө орой ирцээ бүртгүүлэх нөхцөлөөр ханган ажиллалаа мөн эрхээ хаалгасан албан хаагчдын 15 эрхийг сэргээсэн, гар утасны ERP-д заасан алдаа тухай бүрд нь шийдвэрлэж нууц үгийг сольж ажилласан. Эд хөрөнгийн тасгийн дарга Л.Мөнхсарнай, Улсын бүртгэгч З.Отгонмаа, Э.Одончимэг, Бичиг хэрэг Б.Жанчивдорж EDOC эрх нээн албан мэйл солилцох боломжоор ханган ажиллалаа.

Цаг бүртгэл > Нийт ирцийн хүснэгт				Бүх багана		Хайх утгаа оруулна уу														Чөлөөтэй	Ажилласан	Хөдөөрсөн															
№	Нэж	Албан тушаал	Албан хаагчийн нэр	01 Ня	02 Да	03 Мя	04 Лх	05 Пу	06 Ба	07 Бя	08 Ня	09 Да	10 Мя	11 Лх	12 Пу	13 Ба	14 Бя	15 Ня	16 Да	17 Мя	18 Лх	19 Пу	20 Ба	21 Бя	22 Ня	23 Да	24 Мя	25 Лх	26 Пу	27 Ба	28 Бя	29 Ня	30 Да	31 Мя	Чөлөөтэй цаг	Ажилласан цаг	Хөдөөрсөн цаг
1	Уурдала	Хэлтсийн дарга	Ж. Ёгзийвдрал	И	И	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	00:00	168:00	00:00
2	Хяналтын улсын б.	Хяналтын улсын байцаагч	Д. Нямсүрэн	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	160:00	00:00	
3	Иргэний улсын бүр.	Иргэний улсын бүртгэлийн	Б. Сайжангуяа	БД	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	152:00	00:00	
4	Иргэний улсын бүр.	Улсын бүртгэгч	Б. Батбаяр	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	127:53	00:20	
5	Иргэний улсын бүр.	Улсын бүртгэгч	Ш. Чулуунгаргал	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	160:00	00:00	
6	Эд хөрөнгийн зрхи.	Эд хөрөнгийн зрхийн Үл.	О. Гансүх	Х	И	И	И	Х	И	И	И	Х	И	И	Х	И	И	Х	И	И	Х	И	И	Х	И	И	Х	И	И	Х	И	И	00:00	143:30	00:30		
7	Эд хөрөнгийн зрхи.	Эд хөрөнгийн зрхийн Үл.	Н. Уугангуяа	БД	И	И	И	БД	И	И	И	БД	И	И	И	БД	И	И	И	БД	И	И	И	БД	И	И	И	БД	И	И	И	И	00:00	143:29	00:43		
8	Эд хөрөнгийн зрхи.	Эд хөрөнгийн зрхийн бүр.	Л. Мөнхсарнай	И	БД	И	И	БД	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	144:00	00:02		
9	Хуулийн этгээдийн	Хуулийн этгээдийн бүртг.	Б. Содонтулалар	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	08:00	00:34		
10	Захираа аж. ахуй	Мэдээлэл технологийн а.	Г. Алтан-Од	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	00:00	00:00		
11	Захираа аж. ахуй	Мэдээлэл технологийн а.	Б. Жаанчидорж	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	168:00	00:00		
12	Захираа аж. ахуй	Мэдээлэл технологийн а.	Т. Мөнхболд	И	И	И	И	БД	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	152:00	04:32		
13	Захираа аж. ахуй	Ахлах нийтлэн бодогч	Х. Гарам	БД	И	Т	Т	Т	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	142:13	01:47		
14	Захираа аж. ахуй	Няраа	Г. Намжил	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	00:00	00:00		
15	Захираа аж. ахуй	Ариач	Э. Мөнхсүмъяа	И	И	И	И	Ч	Ч	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	176:00	00:00		
16	Захираа аж. ахуй	Ариач гарзат	Ш. Нямсүрэн	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	00:00	00:00		
17	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Ш. Чулуун	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	00:00	00:00	00:00		
18	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	М. Урианзад	Т	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	150:33	01:24		
19	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Ж. Жаанчидорж	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	00:00	47:26	00:48		
20	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Б. Баянжаргал	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	00:00	00:00	00:00		
21	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	С. Сарантуяа	И	Т	И	И	Т	И	И	И	Х	И	И	И	Х	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	135:21	00:39		
22	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Ц. Гэрэлтуяа	Т	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	БД	Т	00:00	00:00	00:00	
23	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Ч. Гантөгс	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	160:00	00:00	
24	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Э. Ариунбилэг	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	00:00	108:12	03:44		
25	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Г. Далгормаа	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	Т	00:00	00:00	00:00		
26	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Б. Санжирваа	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	00:00	00:00		
27	Сумдын бүртгэгч	Улсын бүртгэгч	Э. Одончимэг	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	И	00:00	152:00	00:00		
